



Даатгалын нөхцөл

Та даатгалын нөхцөлтэй танилцана уу

Даатгалын зүйл: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал

Жолооч замын хөдөлгөөнд оролцох үедээ бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учруулж болзошгүй хохирлыг нөхөн төлөх зорилготой бусдын өмнө хүлээх хариуцлага байна.

| ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ | | |
|-------------------|---------------------------------------|--|
| | ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ | Даатгалын үнэлгээ буюу нэг удаа олгох нөхөн төлбөрийн дээд хэмжээ /төгрөг/ |
| 1 | “А” ангиллын тээврийн хэрэгсэл | 5 сая хүртэл |
| 2 | “Б” ангиллын тээврийн хэрэгсэл | 5 сая хүртэл |
| 3 | “С” ангиллын тээврийн хэрэгсэл | 10 сая хүртэл |
| 4 | “Д” ангиллын тээврийн хэрэгсэл | 10 сая хүртэл |
| 5 | “Механизм” ангиллын тээврийн хэрэгсэл | 5 сая хүртэл |

НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ НӨХЦӨЛ

- Даатгагч даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авч шалгахдаа Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг үндэслэнэ.
- Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлын хэмжээг тодорхойлоход Жолоочийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлд, даатгагч нь хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг тогтоож, нөхөн төлбөр олгоход тус хуулийн 19 дүгээр зүйлд заасныг тус тус үндэслэнэ.
- Даатгагч нь Жолоочийн даатгалын тухай хууль болон энэ гэрээнд заасан нөхцөлийн дагуу дараах баримтыг үндэслэн нөхөн төлбөрийг олгоно:
 - Даатгалын гэрээ;
 - Даатгуулагчийн өргөдөл;
 - Шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдээс учирсан хохирлын талаар бичгээр гаргасан дүгнэлт; /Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон /
 - Холбогдох бусад баримт бичиг./Энэ заалтад СЗХ-ны 2020 оны 166 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон/

НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ НӨХЦӨЛ

Дараах хохирол жолоочийн даатгалын тохиолдолд үл хамаарна гэж үзэн даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзана

- Сэтгэл санааны хохирол
- Хүрээлэн байгаа орчныг бохирдуулснаас үүссэн хохирол;
- Даатгуулагчийн автотээврийн хэрэгсэл, ачаанд учирсан хохирол;
- Жолоочийн даатгалын тухай хууль болон энэхүү гэрээнд заасан хэмжээнээс илүү гарсан хохирол.